

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Хайдав	Дугаар	L106
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Мөрөн сум
Төрсөн газар	Мөрөн сумын	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сүүж байсан сүм хийд	Суварганы хийд	Сүм хийдийн дугаар	ХЭМР 063
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 30	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд

Хэнтий аймгийн Мөрөн сумын Суварганы хийд

Хийд байсан юм. Баруун дуган, зүүн дуган, хүрээ дуган гэж 3 дугантай. Өндөрхааны зүүн хойно байдаг байсан. Толгойлогч Өвгөн хамба багш гэж нэг өвгөн байсан. Тэгээд тэр багш маань таалал болсон. Тэгээд хэдэн унзадтай.

-Хэр олон лам нартай байсан юм болоо?

Бас нэг 50,60 аад шахуу лам байсан. 3 дугандаа. Баруун дуган, зүүн дуган, Гүнрэг дуган гэж байсан. Гүнрэг хурдаг байсан. Тэгээд үе үе энэ Хэнтий аймгийнхаа хийдэд ирж цаг цагийн хурал хурдаг байсан. Ийм айл байсан юм.

-Та дуган тус бүрийнх нь лам, унзад нарыг санаж байна уу?

Данзандорж гэж хамгийн их унзад байсан. Гүнрэг дуганд тусгай гүрэм хурдаг унзад байсан. Тэдэн цагт тэдийд гүрэм хурна гэж тусгай хурдаг. Тийм хуралтай байсан юм. Гүнгэр хурдаг лам нар тусдаа байсан. Тэдэн сарын тэдэнд гээд хурдаг байсан. Зүүн дуган баруун дуган гэдэг хоёр нь ээлжийн хуралтай, өглөө болгон хурлаа хурдаг ийм хурал байсан даа.

-Та хэдэн наснаас хэдэн нас хүртлээ тэнд суусан юм бэ?

8 настайд тэр хуралд манай аав эжий нар намайг суулгасан. Миний лам багш том лам байлаа. Тэгээд өглөө номоо аваад явна. Багш нартаа бараалхана. Өчигдөрийн уншсан юмнуудаа шүүлгэнэ. Нэмж заалгаад. Миний багш ном заадаг Чойнзон гэдэг хүн байсан. Чойнзон багшийн хамгийн отгон шавь нь би байлаа. Намайг 21,22 хүрэх үед лам нарыг хар болгохыг шаардаад эхэлсэн. Хар болохгүй бол мөнгө татвар хураадаг байсан. Тэгээд хавчигдаад хар болж хөдөө гарсан юм. Би нэг Равсал төгсөөд Хангал арай төгсгөж чадалгүй хар болсон. Тэгээд хувь заяа ч байдаг юмуу үйл заяа ч байдаг юмуу хар болоод сүүлд нь ном судраа ч мартаж яваа хүн. Хангал үзэж чадалгүй хаясан.

-Та хэдэн настайдаа хар болсон бэ? Хар болсноосоо хойш ямар ажил төрөл хийж байв?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

21,22 настайдаа л байх. 1945 онд намар цэрэгт явж 5 жил алба хаасан. Салаан захирагч ч байж үзсэн. Нэлээн сайн нэртэй яваад өдийг хүрлээ.

-Та Суварганы хийдийг хэдэн онд ямар ноён, ламын санаачлагаар үүссэнийг хэлж өгч чадах уу?

Чухам хэдэн онд гэдгийг хэлж чадахгүй.

-Хэн гэдэг хүн байгуулсан юм бол?

Шүхэр бэйс гэдэг ноён байсан.

-Майдар эргэж цам гардаг байсан уу?

Гардаггүй байсан. Цам,Майдарт Хутагтын хүрээ рүү явдаг байлаа.

Энд ямар ямар онцлог хурлууд болдог байсан бэ?

Элдэв өнгийн бурханыг тахиж гарна даа. Янз бүрийн хурал хурна.

-Ер нь хурлуудад хурдаг байсан 29-ний хуучин хурал байдаг ч юм уу, жилийн, сарын ямар ямар хурал хурдаг байсан бэ?

Янз бүрийн. Хайлан хурна. Цаг цагийн янз бүрийн хурал хурдаг, хуруулдаг байсан. Ард түмэн ч хуруулна.

-Маанийн бүтээл хийдэг байсан уу?

Маанийн бүтээл хурна.

-Гүнрэгийн хурлын талаар яриач, ямар онцлогтой хурал байсан бэ?

Гүнрэг яахав дээ. Тусгай хувцастай. Их сурамгай дадамгай уншина л даа. Шүхэр бэйс гэдэг хүн удирддаг байсан.

Хэнтий аймгийн нэг хошуу ноён.

-Та суварганы хийдэд хүрж байхдаа ямар албатай байв? Юу хийдэг байв?

Ямар ч алба байгаагүй. Равсал төгсөөд Хангал төгсгөж чадаагүй.

-Баруун зүүн дуганын унзад нарын нэрийг хэлээч?

Данзанчүлтэм гэж дуу хоолой сайхантай унзад байсан. Дуу хоолой сайхантай янз бүрийн янтай олон сайхан унзад байсан.

-Зүүн хурлынх нь унзад хэн байсан юм бэ?

Одоо нэр нь орж ирэхгүй байна. Зөндөө л хүн байсан. Баруун дуганын их унзад Данзан гэдэг хүн байсан.

-Гэсгүй лам нь ямар лам байсан?

Янз бүрийн лам нар байсан. Миний ном заадаг багш гэсгүй байсан. Бүгд л тэгээд баригдчихсан даа.

-Суварганы хийдийн гол сахиус нь ямар сахиус байсан бэ?

Гомбо сахиус гол нь. Говийн Лха, Таван сахиус тахидаг байсан. Айлууд жасаа их авахуулдаг байсан. Намар болохоор.

-Жасаа намар хурдаг байсан уу?

Намар хурдаг байсан. Хэнгэрэг, цантай нижгэр хийнэ л дээ. Олон балингууд байна.

-Хайлан хэдүйд хурдаг байсан бэ?

Намар хурна.